**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

"Шивээговь сумын Эрүүл мэндийн төв"-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ГСА-2022/58/СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Утас: 70543179
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Аудитор: С.Батцэцэг
Утас:70543179
Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Цахим хуудас:
www.audit.mn


Чойр хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....13
3. Аудитын тайлан....14
3.1 Ерөнхий зүйл....14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....14
3.4 Материаллаг байдал....15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....17
3.8 Аудитын гол асуудал....17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд....18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй....18
4. Аудитын илрүүлэлт....18
4.1 Залруулсан алдаа....18
4.2 Төлбөрийн акт....19
4.3 Албан шаардлага....19
4.4 Зөвлөмж....20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОУБ | Олон улсын байгууллага |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2022 · 02 · 25 № 33

танай ____________-ны № ______________-т

ШИВЭЭГОВЬ СУМЫН "ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ"-ИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Х.СУВДАНЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шивээговь сумын "Эрүүл мэндийн төв"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020099

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **64,003,853.46** | **326,814,650.81** |
| **2** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **658,453** | **14,343.39** |
| 3 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 658,453 | 14,343.39 |
| 4 | Төгрөг | 658,453 | 14,343.39 |
| 5 | Төрийн сангийн харилцах | | 12,000 |
| 6 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 658,453 | 1,253 |
| 7 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | | 1,090.39 |
| **8** | **АВЛАГА** | | **230,537,700** |
| 9 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 230,537,700 |
| **10** | **БАРАА МАТЕРИАЛ** | **50,641,422.66** | **72,269,069.82** |
| 11 | Түүхий эд материал | 20,771,853.66 | 39,008,383.32 |
| 12 | Эм боох материал | 20,771,853.66 | 39,008,383.32 |
| 13 | Хангамжийн материал | 29,869,569 | 33,260,686.5 |
| 14 | Бичиг хэргийн материал | 1,015,950 | 752,900 |
| 15 | Аж ахуйн материал | 5,698,600 | 1,243,250 |
| 16 | Сэлбэг хэрэгсэл | | 429,000 |
| 17 | Түлш, шатах тослох материал | 4,537,000 | |
| 18 | Хүнсний материал | 2,303,629 | 951,426.5 |
| 19 | Бусад хангамжийн материал | 16,314,390 | 29,884,110 |
| 20 | НӨӨЦИЙН БАРАА | 12,703,977.8 | 23,993,537.6 |
| 21 | Бусад нөөц | 12,703,977.8 | 23,993,537.6 |
| **22** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,470,908,117.62** | **1,280,291,162.58** |
| **23** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,470,908,117.62** | **1,280,291,162.58** |
| 24 | Биет хөрөнгө | 1,452,793,117.62 | 1,262,266,162.58 |
| 25 | Барилга, байгууламж, орон сууц | 1,546,397,717.31 | 1,546,397,717.31 |
| 26 | Хуримтлагдсан элэгдэл | -209,634,901.64 | -475,677,801.32 |
| 27 | Авто-тээврийн хэрэгсэл | 37,440,000 | 37,440,000 |
| 28 | Хуримтлагдсан элэгдэл | -10,693,999.84 | -19,371,999.76 |
| 29 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 170,860,020.3 | 259,978,257.3 |
| 30 | Хуримтлагдсан элэгдэл | -89,765,357.53 | -111,815,372.83 |
| 31 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,124,898.91 | 38,055,898.91 |
| 32 | Хуримтлагдсан элэгдэл | -9,935,259.89 | -12,740,537.03 |
| 33 | Биет бус хөрөнгө | 18,115,000 | 18,025,000 |
| 34 | Програм хангамж | 1,180,000 | 1,180,000 |
| 35 | Хуримтлагдсан элэгдэл | -865,000 | -955,000 |
| 36 | Бусад биет бус хөрөнгө | 17,800,000 | 17,800,000 |
| **37** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,534,911,971.08** | **1,607,105,813.39** |
| **38** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **27,081,805.22** |
| **39** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **27,081,805.22** |
| 40 | Өглөг | | 27,081,805.22 |
| 41 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 17,249,543.27 |
| 42 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 9,832,261.95 |
| **43** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,534,911,971.08** | **1,580,024,008.17** |
| 44 | Засгийн газрын хувь оролцоо | 1,534,911,971.08 | 1,580,024,008.17 |
| 45 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 263,902,032 | 263,902,032 |
| 46 | Хуримтлагдсан үр дүн | 1,129,086,648.94 | 1,174,198,686.03 |
| 47 | Өмнөх үеийн үр дүн | 1,096,493,650.15 | 1,129,086,648.94 |
| 48 | Тайлант үеийн үр дүн | 32,592,998.79 | 45,112,037.09 |
| 49 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 141,923,290.14 | 141,923,290.14 |
| **50** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,534,911,971.08** | **1,607,105,813.39** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **594,676,654.9** | **1,265,613,084.2** |
| **2** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **128,488,608.9** | **396,918,269.2** |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 128,488,608.9 | 396,918,269.2 |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,709,453 | |
| 5 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,709,453 | |
| 6 | Бусад орлого | 607,455 | |
| 7 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 75,048,375 | 99,049,637 |
| 8 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 51,123,325.9 | 297,868,632.2 |
| **9** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **466,188,046** | **868,694,815** |
| 10 | Улсын төвлөрсөн төсвөөс | 365,740,900 | 386,998,600 |
| 11 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 365,740,900 | 386,998,600 |
| 12 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 16,453,076 | 423,026,625 |
| 13 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,000,000 | 178,290,075 |
| 14 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,453,076 | 14,198,850 |
| 15 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | 230,537,700 |
| 16 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 52,674,300 | 50,507,700 |
| 17 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 52,674,300 | 50,507,700 |
| 18 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 31,319,770 | 8,161,890 |
| 19 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 31,319,770 | 8,161,890 |
| **20** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **551,645,047.98** | **1,220,501,047.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **551,645,047.98** | **1,220,501,047.11** |
| **22** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **548,607,228.91** | **1,172,129,507.11** |
| 23 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 299,329,543.35 | 370,747,303 |
| 24 | Үндсэн цалин | 201,807,763.38 | 370,747,303 |
| 25 | Нэмэгдэл | 82,070,957.79 | |
| 26 | Урамшуулал | 15,450,822.18 | |
| 27 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,773,604.01 | 48,986,001.25 |
| 28 | Тэтгэврийн даатгал | 26,897,310.97 | 35,000,852.25 |
| 29 | Тэтгэмжийн даатгал | 2,972,700 | 3,926,737 |
| 30 | ҮОМШӨ-ний даатгал | 2,379,200 | 2,953,231 |
| 31 | Ажилгүйдлийн даатгал | 595,600 | 645,927 |
| 32 | Эрүүл мэндийн даатгал | 5,928,793.04 | 6,459,254 |
| 33 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 46,631,960.73 | 56,114,391.95 |
| 34 | Гэрэл, цахилгаан | 5,433,819.33 | 4,794,424.95 |
| 35 | Түлш, халаалт | 35,248,141.4 | 41,073,847 |
| 36 | Цэвэр, бохир ус | 5,950,000 | 10,246,120 |
| 37 | Хангамж, бараа материалын зардал | 17,431,605.64 | 34,702,946 |
| 38 | Бичиг хэрэг | 2,754,950 | 3,804,850 |
| 39 | Тээвэр, шатахуун | 9,640,000 | 15,880,800 |
| 40 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,661,355.64 | 1,663,450 |
| 41 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 588,600 | 735,000 |
| 42 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,786,700 | 12,618,846 |
| 43 | Нормативт зардал | 45,158,441.49 | 282,104,888.76 |
| 44 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,879,634.99 | 263,331,828.26 |

| | | | |
|---|---|---|---|
| 45 | Хоол, хүнс | 5,278,806.5 | 18,773,060.5 |
| 46 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,561,065 | |
| 47 | Багаж, техник, хэрэгсэл | 800 | |
| 48 | Урсгал засвар | 1,560,265 | |
| 49 | Томилолт, зочны зардал | 580,000 | 1,159,995 |
| 50 | Дотоод албан томилолт | 580,000 | 1,159,995 |
| 51 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,378,850 | 967,800 |
| 52 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000 | |
| 53 | Даатгалын үйлчилгээ | 679,350 | 612,000 |
| 54 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,500 | 55,800 |
| 55 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000 | 44,000 |
| 56 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 620,000 | 240,000 |
| 57 | Газрын төлбөр | | 16,000 |
| 58 | Бараа үйлчилгээний бусад зардал | 96,762,158.69 | 377,346,181.15 |
| 59 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,283,910.7 | 77,679,989.11 |
| 60 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 76,478,247.99 | 299,666,192.04 |
| **61** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,037,819.07** | **48,371,540** |
| 62 | Бусад урсгал шилжүүлэг | 1,686,180 | 48,371,540 |
| 63 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,686,180 | 48,371,540 |
| 64 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,335,667.78 | |
| 65 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,321,579.27 | |
| 66 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 14,088.51 | |
| 67 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 15,971.29 | |
| 68 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,971.29 | |
| **69** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **43,031,606.92** | **45,112,037.09** |
| **70** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **10,438,608.13** | |
| **71** | **Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз** | **10,438,608.13** | |
| **72** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **32,592,998.79** | **45,112,037.09** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,902,032** | **141,923,290.14** | **1,107,937,973.11** | **1,513,763,295.25** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -11,444,322.96 | -11,444,322.96 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 263,902,032 | 141,923,290.14 | 1,096,493,650.15 | 1,502,318,972.29 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | | | 32,592,998.79 | 32,592,998.79 |
| **5** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,902,032** | **141,923,290.14** | **1,129,086,648.94** | **1,534,911,971.08** |
| **6** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **263,902,032** | **141,923,290.14** | **1,129,086,648.94** | **1,534,911,971.08** |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -263,902,032 | -141,923,290.14 | -1,129,086,648.94 | -1,534,911,971.08 |
| 8 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 263,902,032 | 141,923,290.14 | 1,129,086,648.94 | 1,534,911,971.08 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 45,112,037.09 | 45,112,037.09 |
| **10** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **263,902,032** | **141,923,290.14** | **1,174,198,686.03** | **1,580,024,008.17** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **467,897,499** | **638,157,115** |
| **2** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,709,453** | |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 1,709,453 | |
| 4 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,709,453 | |
| 5 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,709,453 | |
| **6** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **466,188,046** | **638,157,115** |
| 7 | Улсын төвлөрсөн төсвөөс | 365,740,900 | 386,998,600 |
| 8 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 365,740,900 | 386,998,600 |
| 9 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 16,453,076 | 192,488,925 |
| 10 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,000,000 | 178,290,075 |
| 11 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,453,076 | 14,198,850 |
| 12 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 52,674,300 | 50,507,700 |
| 13 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 52,674,300 | 50,507,700 |
| 14 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 31,319,770 | 8,161,890 |
| 15 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 31,319,770 | 8,161,890 |
| **16** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **464,729,046** | **628,801,624.61** |
| **17** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **464,729,046** | **628,801,624.61** |
| **18** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **461,691,226.93** | **580,430,084.61** |
| 19 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 298,722,088.35 | 351,129,327.9 |
| 20 | Үндсэн цалин | 201,200,308.38 | 150,439,883.9 |
| 21 | Нэмэгдэл | 82,070,957.79 | 179,414,665 |
| 22 | Урамшуулал | 15,450,822.18 | 21,274,779 |
| 23 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,773,604.01 | 51,354,433.08 |
| 24 | Тэтгэврийн даатгал | 26,897,310.97 | 34,615,957.2 |
| 25 | Тэтгэмжийн даатгал | 2,972,700 | 4,070,564 |
| 26 | ҮОМШӨ-ний даатгал | 2,379,200 | 3,809,754 |
| 27 | Ажилгүйдлийн даатгал | 595,600 | 869,191 |
| 28 | Эрүүл мэндийн даатгал | 5,928,793.04 | 7,988,966.88 |
| 29 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 44,652,720.73 | 49,174,300 |
| 30 | Гэрэл, цахилгаан | 5,433,819.33 | 4,794,424.95 |
| 31 | Түлш, халаалт | 33,268,901.4 | 36,879,875.05 |
| 32 | Цэвэр, бохир ус | 5,950,000 | 7,500,000 |
| 33 | Хангамж, бараа материалын зардал | 22,991,405.64 | 19,607,550 |
| 34 | Бичиг хэрэг | 3,520,900 | 3,388,800 |
| 35 | Тээвэр, шатахуун | 14,177,000 | 11,043,800 |
| 36 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,661,355.64 | 1,663,450 |
| 37 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 692,600 | 735,000 |
| 38 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,939,550 | 2,776,500 |
| 39 | Нормативт зардал | 36,176,053.2 | 94,047,622.63 |
| 40 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,982,647.7 | 74,432,764.63 |
| 41 | Хоол, хүнс | 7,538,005.5 | 17,084,858 |
| 42 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,655,400 | 2,530,000 |
| 43 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,504,015 | 11,031,856 |
| 44 | Багаж, техник, хэрэгсэл | 1,206,200 | |
| 45 | Урсгал засвар | 7,297,815 | 11,031,856 |

| | | | |
|---|---|---|---|
| 46 | Томилолт, зочны зардал | 580,000 | 1,159,995 |
| 47 | Дотоод албан томилолт | 580,000 | 1,159,995 |
| 48 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,378,850 | 967,800 |
| 49 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000 | |
| 50 | Даатгалын үйлчилгээ | 679,350 | 612,000 |
| 51 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,500 | 55,800 |
| 52 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000 | 44,000 |
| 53 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 620,000 | 240,000 |
| 54 | Газрын төлбөр | | 16,000 |
| 55 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,912,490 | 1,957,200 |
| 56 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,912,490 | 1,957,200 |
| **57** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,037,819.07** | **48,371,540** |
| 58 | Бусад урсгал шилжүүлэг | 1,686,180 | 48,371,540 |
| 59 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,686,180 | 48,371,540 |
| 60 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,335,667.78 | |
| 61 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,321,579.27 | |
| 62 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 14,088.51 | |
| 63 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 15,971.29 | |
| 64 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,971.29 | |
| **65** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **3,168,453** | **9,355,490.39** |
| **66** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **2,510,000** | **9,999,600** |
| **67** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,510,000** | **9,999,600** |
| 68 | Дотоод эх үүсвэрээр | 2,510,000 | 9,999,600 |
| 69 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,510,000 | 9,999,600 |
| **70** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-2,510,000** | **-9,999,600** |
| **71** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **658,453** | **-644,109.61** |
| 72 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 658,453 |
| 73 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 658,453 | 14,343.39 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **464,833,700** | **445,656,190** | **19,177,510.00** |
| **2** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **464,833,700** | **445,656,190** | **19,177,510.00** |
| **3** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **463,861,700** | **444,696,190** | **19,165,510.00** |
| **4** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **329,527,700** | **329,526,612.95** | **1,087.05** |
| 5 | Үндсэн цалин | 204,174,000 | 128,837,168.95 | 75,336,831.05 |
| 6 | Нэмэгдэл | 95,338,500 | 179,414,665 | 8,740,421.00 |
| 7 | Урамшуулал | 30,015,200 | 21,274,779 | 8,740,421.0 |
| **8** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **44,579,800** | **30,309,582.03** | **14,270,217.97** |
| 9 | Тэтгэврийн даатгал | 31,370,500 | 18,846,923.15 | 12,523,576.85 |
| 10 | Тэтгэмжийн даатгал | 3,301,200 | 3,015,400 | 285,800.00 |
| 11 | ҮОМШӨ-ний даатгал | 2,642,400 | 2,490,800 | 151,600.00 |
| 12 | Ажилгүйдлийн даатгал | 661,200 | 605,400 | 55,800 |
| 13 | Эрүүл мэндийн даатгал | 6,604,500 | 5,351,058.88 | 1,253,441.12 |
| **14** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,174,300** | **49,174,300** | **0.00** |
| 15 | Гэрэл, цахилгаан | 6,000,000 | 4,794,424.95 | 1,205,575.05 |
| 16 | Түлш, халаалт | 35,674,300 | 36,879,875.05 | -1,205,575.05 |
| 17 | Цэвэр, бохир ус | 7,500,000 | 7,500,000 | 0 |
| **18** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,152,000** | **16,754,650** | **2,397,350.00** |
| 19 | Бичиг хэрэг | 3,000,000 | 2,966,900 | 33,100.00 |
| 20 | Тээвэр, шатахуун | 13,020,000 | 10,900,000 | 2,120,000.00 |
| 21 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,692,000 | 1,663,450 | 28,550.00 |
| 22 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000 | 240,000 | 0 |
| 23 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,200,000 | 984,300 | 215,700.00 |
| **24** | **Нормативт зардал** | **18,821,000** | **16,629,845.02** | **2,191,154.98** |
| 25 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,700,000 | 11,648,502.02 | 51,497.98 |
| 26 | Хоол, хүнс | 7,121,000 | 4,981,343 | 2,139,657.00 |
| 27 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,333,400 | 1,333,400 | 0 |
| 28 | Урсгал засвар | 1,333,400 | 1,333,400 | 0 |
| **29** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,273,500** | **967,800** | **305,700.00** |
| 30 | Даатгалын үйлчилгээ | 679,500 | 612,000 | 67,500.00 |
| 31 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,000 | 55,800 | 34,200.00 |
| 32 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000 | 44,000 | 0.00 |
| 33 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,000 | 240,000 | 160,000.00 |
| 34 | Газрын төлбөр | 60,000 | 16,000 | 44,000.00 |
| **35** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **972,000** | **960,000** | **12,000.00** |
| 36 | Бусад урсгал шилжүүлэг | 972,000 | 960,000 | 12,000.00 |
| 37 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 972,000 | 960,000 | 12,000.00 |
| **38** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **464,833,700** | **445,668,190** | **19,165,510.00** |
| **39** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **386,998,600** | **386,998,600** | 0.00 |
| 41 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 386,998,600 | 386,998,600 | 0.00 |
| **42** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **50,507,700** | **50,507,700** | 0.00 |
| 43 | Орон нутгийн төсвөөс | 50,507,700 | 50,507,700 | 0.00 |
| **44** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **27,327,400** | **8,161,890** | **19,165,510.00** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 45 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 27,327,400 | 8,161,890 | 19,165,510.00 |
| 46 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 12,000 | 12,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 658,453.00 | -658,453.00 |
| **1** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **193,145,034.61** | **-193,145,034.61** |
| **2** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **193,145,034.61** | **-193,145,034.61** |
| **3** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 145,733,494.61 | -145733494.61 |
| **4** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 21,602,714.95 | -21,602,714.95 |
| 5 | Үндсэн цалин | | 21,602,714.95 | -21,602,714.95 |
| **6** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 21,044,851.05 | -21,044,851.05 |
| 7 | Тэтгэврийн даатгал | | 15,769,034.05 | - 15,769,034.05 |
| 8 | Тэтгэмжийн даатгал | | 1,055,164.00 | -1,055,164.00 |
| 9 | ҮОМШӨ-ний даатгал | | 1,318,954.00 | -1,318,954.00 |
| 10 | Ажилгүйдлийн даатгал | | 263,791.00 | - 263,791.00 |
| 11 | Эрүүл мэндийн даатгал | | 2,637,908.00 | -2,637,908.00 |
| **12** | **Хангамж, бараа материалын зардал** | | 2,852,900.00 | -2,852,900.00 |
| 13 | Бичиг хэрэг | | 421,900.00 | - 421,900.00 |
| 14 | Тээвэр, шатахуун | | 143,800.00 | -143,800.00 |
| 15 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 495,000.00 | -495,000.00 |
| 16 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1,792,200.00 | -1,792,200.00 |
| **17** | **Нормативт зардал** | | 77,417,777.61 | -77,417,777.61 |
| 18 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 62,784,262.61 | -62,784,262.61 |
| 19 | Хоол, хүнс | | 12,103,515.00 | -12,103,515.00 |
| 20 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 2,530,000.00 | -2,530,000.00 |
| **21** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 19,698,056.00 | -19,698,056.00 |
| 22 | Багаж, техник, хэрэгсэл | | 9,999,600.00 | -9,999,600.00 |
| 23 | Урсгал засвар | | 9,698,456.00 | -9,698,456.00 |
| **24** | **Томилолт, зочны зардал** | | 1,159,995.00 | -1,159,995.00 |
| 25 | Дотоод албан томилолт | | 1,159,995.00 | -1,159,995.00 |
| **26** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 1,957,200.00 | -1,957,200.00 |
| 27 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,957,200.00 | -1,957,200.00 |
| **28** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 47,411,540.00 | -47,411,540.00 |
| **29** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 47,411,540.00 | -47,411,540.00 |
| 30 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 47,411,540.00 | -47,411,540.00 |
| **31** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 192,488,925.00 | -192,488,925.00 |
| **32** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 192,488,925.00 | -192,488,925.00 |
| 33 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 178,290,075.00 | -178,290,075.00 |
| 34 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 14,198,850.00 | -14,198,850.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Шивээговь сумын Эрүүл мэндийн төв”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн ашиглалт, ажилд томилох тушаалд нэмэгдлүүдийг тодорхой тусгах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Шивээговь сумын Эрүүл мэндийн төв”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 7 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Шивээговь сумын Эрүүл мэндийн төв” нь сумын иргэдэд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх нэмэлт тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулсан Жишиг эрүүл мэндийн төв болох зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шивээговь сумын Эрүүл мэндийн төв” 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “нийт зардал” сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний 475,127.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,751.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувь буюу 3,563.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Шивээговь сумын Эрүүл мэндийн төв”-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72,193.9 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүний дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 658.4 | 14.3 | -644.1 |
| Авлага | - | 230,537.7 | 230,537.7 |
| Бараа материал | 63,345.4 | 96,262.6 | 32,917.2 |
| Үндсэн хөрөнгө | 1,470,908.1 | 1,280,291.2 | -190,616.9 |
| **Нийт хөрөнгө** | **1,534,912.9** | **1,607,105.8** | **72,193.9** |
| Өр төлбөр | 0.0 | 27,081.8 | 27,081.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 263,902.0 | 263,902.0 | 0.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,129,086.6 | 1,174,198.7 | 45,112.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 141,923.3 | 141,923.3 | 0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,534,912.9** | **1,607,105.8** | **72,193.9** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 14.3 мянган төгрөг нь өмнөх оноос 644.1 мянган төгрөгөөр буурсан өмнөх оны Ахмадын сангийн үлдэгдэл бөгөөд тайлант онд төвлөрүүлэх шилжүүлэг хийгдээгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл болох 230,537.7 мянган төгрөг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн дүнгээр нэмэгдсэн бөгөөд тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,262.6 мянган төгрөг болж 32,917.2 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал, бусад хангамжийн материал, бусад нөөцийн бараа нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,280,291.2 мянган төгрөг болж 190,616.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө нь тайлант хугацаанд нийт 109,049.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд Шивээговь сумын ОНХС-аас сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/220 дугаар захирамжаар тоног төхөөрөмж 17,980.0 мянга, Эрүүл мэндийн яамнаас тоног төхөөрөмж 64,313.6 мянга, тавилга эд хогшилд 14,506.0 мянга, иргэдийн хандиваар 2,250.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө бүртгэсэн, өөрийн хөрөнгөөр 9,999.6 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж болон тавилга эд хогшлын худалдан авалт хийсэн байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 1,174,198.2 мянган төгрөг болж, 45.112.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн үнэ төлбөргүй орлого, ЭМДС-гийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлогоос шалтгаалжээ.

“Шивээговь сумын Эрүүл мэндийн төв”-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 670,936.5 мянган төгрөгөөр буюу 112.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 668,856.0 мянган төгрөгөөр буюу 121.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, тогтмол зардал, хангамжийн бараа материал, нормативт зардал, дотоод томилолтын зардал, бараа ажил үйлчилгээ бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт ороогүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 456,994.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 456,994.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 7,838.8 мянган төгрөгөөр нэмж 464,833.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс нэмж баталсан нь цалин хөлс, тогтмол зардал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардалд холбоотойгоор нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71602 /Эмнэлгийн тусламж үйлчилгээ/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 464,833.7 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвийн хуваарийг 2 удаагийн өөрчлөлт орсон бөгөөд зардлын зохицуулалт хийжээ.

Гүйцэтгэлээр нийт 464,833.7 мянган төгрөгөөс тусгай зориулалтын шилжүүлгээс 386,998.6 мянга, орон нутгийн төсвөөс 50,507.7 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 27,327.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 445,656.2 мянган төгрөгийг зарцуулж, 19,165.5 мянган төгрөгийн эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу санхүүжилт ирсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 445,656.2 мянга буюу 95.9 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 1.1 мянга, НДШ зардлаас 14,270.2 мянга, бичиг хэргийн зардлаас 33.1 мянга, тээвэр шатахууны зардлаас 2,210.0 мянга, шуудан холбооны зардлаас 28.5 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 215.7мянга, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 51.5 мянга, хоол, хүнсний зардлаас 2,139.5 мянга, даатгалын үйлчилгээний зардлаас 67.5 мянга, тээврийн хэрэгслийн татварын зардлаас 34.2 мянга, газрын төлбөрийн зардлаас 44.0 мянга, мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 160.0мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжилт зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 2 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 19,165.5 мянган төгрөгийн дутуу санхүүжилт гарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн яамнаас 178,290.1 мянга, үндсэн ажиллагааны орлогоос 14,198.8 мянган төгрөгийг цалингийн зардал 21,602.7 мянга, НДШ зардал 21,044.8 мянга, хангамж, бараа материалын зардал 2,852.9 мянга, нормативт зардал 77,417.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 19,698.0 мянга, дотоод томилолтын зардал 1,160.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,957.2 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 47,411.5 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Шивээговь сумын Эрүүл мэндийн төв” нь 2021 онд нийт 464,883.7 мянган төгрөгийн 175 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан ба 4 мэдээлэл хоцроосон нь материаллаг бус зөрчил гэж үзлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгахад хуульд нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,949.8 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 15,858.4 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 91.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 4 | 91.3 | 4 | 91.3 | - | - | - |
| Албан шаардлага | 1 | 0 | 1 | 0 | | | |
| **Нийт дүн** | **5** | **91.3** | **5** | **91.3** | | | **-** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 58,590.2 мянган төгрөгийн 13 алдаа зөрчил илэрснээс, 13,474.6 мянган төгрөгийн 5 алдааг завсрын аудитаар, 1,227.7 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 4,004.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 39,883.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай нийт 58,590.2 мянган төгрөгийн залруулгаас 13,474.6 мянган төгрөгийг

завсрын аудитаар, 1,227.7 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нийт 8,193.2 мянган төгрөгийн өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийн завсрын аудитаар залруулсан.
2. Нийт 4,246.7 мянган төгрөгийн цалингийн зардлыг бууруулах бичилт хийсэн зөрчил илэрсэн бөгөөд завсрын аудитаар 3,019.0 мянга, аудитын явцад 1,227.7 мянган төгрөгийн зөрчлийг тус тус залруулсан
3. Шатахууны 800.0 мянган төгрөгийн материалын орлогыг санхүүгийн тайланд дутуу тусгасан алдааг залруулсан.
4. Вакум хаалга, хаалтыг барилга байгууламжид бүртгэснийг залруулсан.
5. Барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, программ хангамж, бусад биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй тайланг улирал бүр гаргах талаар завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу залруулсан.

**4.2 Төлбөрийн акт**

**4.2.1** Албан хаагчдад хууль, тогтоомжид заагдаагүй буцалтгүй тусламж, тэтгэмж олгохдоо нийт 2,130.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

**4.3 Албан шаардлага**

**4.3.1** Татварын цахим бүртгэлийн системд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтыг тулган баталгаажуулаагүйгээс 1,624.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

**4.3.2** Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр батлагдсан орон тоог нэмэгдүүлсэн, үндэслэлгүй нэмэгдүүлсэн орон тооны тушаалаар хавсарсан ажлын нэмэгдэлд 4,876.4 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.12, 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20 дэх заалтуудыг тус тус зөрчсөн ба эрх ба үүрэг байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

**4.3.3** Тусгай зориулалтын материал болох нийт 23,993.5 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгслийг бусад нөөцийн бараанд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2 дахь заалтыг тус тус зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв

.

**4.3.4** Цалингийн зардлыг зориулалт бусаар зарцуулж 1,874.9 мянган төгрөгийн шагнал, урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Дотоод хяналттай холбоотой асуудал***

*<u>1.1. Илрүүлэлт:</u>*

Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгүүдийг актлах болон дахин үнэлж ашиглаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтуудыг зөрчсөн ба “иж бүрэн байх, оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*<u>1.2. Өгсөн зөвлөмж:</u>*

Анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх болон шаардлага хангаагүй үндсэн хөрөнгийг актлах ажлыг зохион байгуулах

***2. Хууль тогтоомжтой холбоотой асуудал***

*<u>2.1. Илрүүлэлт:</u>*

Ажилтныг ажилд томилсон тушаалд цалингийн нэмэгдлүүдийг тодорхой зааж өгөөгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, 48 дугаар зүйлийн 48.3.4, Төрийн албаны тухай 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалтуудыг зөрчсөн ба эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*<u>2.2. Өгсөн зөвлөмж</u>*

Цаашид ажилд томилсон тушаалд цалингийн нэмэгдлүүдийг тодорхой бичиж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Шивээговь сумын Эрүүл мэндийн төв | 13 | 57,639.9 | 6 | 14,702.3 | 1 | 2,130.0 | 4 | 40,807.6 | 2 | - |